



DSES – DGS
Service du médecin cantonal
Rue Adrien-Lachenal 8
1207 Genève

Женев хот, 2020 оны 12 сарын 28

Хамрах хүрээ: КОВИД-19 халдварт вирусын эсрэг вакцин

Хадагтай, Ноёнтон,

КОВИД-19 халдварт вирус нь ужиг өвчтэй болон 65-аас дээш насны хүмүүст хүндрэл учруулж байгааг та бүхэн сайн мэдэж байгаа.

Швейцарь улсад одоогийн байдлаар 95 хувийн чанартай вакцин байна. 100 хүнд вакцин хийсний дараа эдгээр хүмүүсээ халдвар авах боломжтой нөхцөлд байлгаад судалгаа хийж үзэхэд 95 хүн нь энэ вируснээс бүрэн хамгаалагдсан бол 5 хүн нь энэхүү вирусыг хөнгөн тусах боломжтойг харуулсан.

Дэлхий дээр олон мянган хүмүүс энэхүү вакциныг хийлгээд байна. Вакцин хийлгэсний дараа ажиглагдсан шинж тэмдэгүүд нь тарилга хийлгэсэн газар өвдөх, ядрах, толгой өвдөх, бие хөндүүрлэх гэх мэт юм. Дээр дурьдсан шинж тэмдэгүүдээс гадна бусад үрэвсэл гарч байгаа ч тэр нь маш ховор.

Одоогийн байдлаар КОВИД-19 халдварт вирус болон түүнээс үүдэх хүндрэлүүдийн эсрэг зөвхөн вакцин хийлгэх нь үр дүнтэй арга юм. **Эрүүл ахуйн удирдах байгууллага болон эмч нар вакцин хийлгэхийг танд зөвлөж байна. Вакцин үнэ төлбөргүй ч заавал хийлгэх шаардлагагүй.** Та энэ хавсралтаас илүү өргөн мэдээлэл авах боломжтой. Өрхийнхөө эмч, байгууллагынхаа удирлагатай болон ойр дотны хүмүүстэйгээ ярилцаж зөв шийдвэрийг гаргахыг зөвлөж байна.

Хэрвээ та 75-аас дээш настай бол хамгийн түрүүнд буюу нэгдүгээр сарын 4-нөөс эхлэн вакцинд хамрагдах боломжийг олгож байна.

Хэрвээ та эдгээр байгууллагын (EMS, IEPA, EPH гэх мэт) харьяанд байдаг бол бүх оршин суугчидыг нийтээр вакцинд хамруулах өндөр магадлалтай. Иймээс та өөрийнхөө амьдардаг байгууллагын удирдлагаас асууж лавлаарай.

Хэрэв та эдгээр байгууллагын аль нэгэнд амьдардаггүй бол та цахим хаягаар хамрагдах хүсэлтээ бүртгүүлж болно. Бүртгэлийн холбоосыг эндээс харна уу. www.ge.ch/se-faire-vacciner-contre-covid-19/inscription-vaccination. Хэрвээ та өөрөө бүртгүүлэх боломжгүй бол ойр дотныхоо хүнээс тусламж хүсээрэй. Танд туслах хүн байхгүй тохиолдолд энэ дугаараар холбогдоорой 0800 909 400 Ligne Verte genevoise.

Бүртгэлийн үеэр та вакцин хийлгэх эмнэлэгээ сонгож болно. Вакцины тоо хязгаартай тул вакцин хийлгэх уулзалтын цаг авахад хүлээлт үүсэх магадлалтайг мэдэгдэж байна.

Таныг хүндэтгэсэн

Женев Контуну эмч Аглае Тардин